

УЛСЫН ШАЛГАЛТ - 2025

ТҮҮХ ХИИ АНГИ А хувилбар

Аймаг/дүүрэг:

Сум:.....

Сургууль:

Анги:..... бүлэг:.....

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Амжилт хүсье.

ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН 12 ДУГААР АНГИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ

А ХУВИЛБАР

80 МИНУТ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Аль нь хуучин чулуун зэвсгийн доод үе вэ? /1 оноо/
 - A. 15 000-8000 жилийн үед
 - B. 100 000-40 000 жилийн үед
 - C. 40 000-15 000 жилийн үед
 - D. 800 000-100 000 жилийн үед
2. Түрүү түүхийн үеийн Монгол нутагт оршин тогтнож байсан улсуудын тухай мэдээлэл ямар эх сурвалжид хадгалагдсан байдаг вэ? /2 оноо/
 - A. Монголын нууц товчоо
 - B. Хятад, Солонгосын түүхэн сурвалжууд
 - C. Түрэгийн бичээсүүд
 - D. Оросын түүхэн сурвалжууд
3. Дараах шинжүүдээс “Хүрэл, төмөр зэвсгийн үед бүрэлдсэн овог аймгийн холбоо”-нд хамаарахгүй шинжийг сонгоно уу. /1 оноо/
 - A. Ураг төрлийн холбоо бүхий овгуудын нэгдэл
 - B. Цэргийн захиргаанд төвлөрсөн хүчтэй удирдлагын бүтэцтэй байв
 - C. Нэгэн ижил хэл аялгуугаар ярьдаг байсан
 - D. Төр үүсээгүй нийгмийн зохион байгуулалттай байсан
4. “Монгол орныг дэлхийн хүрэл зэвсгийн үйлдвэрлэлийн нэгэн томоохон төв гэж үздэгийн шалтгаан нь буган хөшөө, дөрвөлжин булш зэрэг дурсгалууд өргөн тархсан байдагтай холбоотой.” Энэ мэдээллийн үндсэн дүгнэлт аль нь вэ? /2 оноо/
 - A. Монголд хүрлийн үеийн гоёл чимэглэлийн зүйл өргөн хэрэглэгдэж байжээ.
 - B. Монгол нутагт хүрэл зэвсгийн соёл эрчимтэй хөгжсөн.
 - C. Монголын хүрэл зэвсгийн үе Хятадтай адил байжээ.
 - D. Буган хөшөө нь зөвхөн монголчуудын бүтээл биш байж болно.
5. Эртний нүүдэлчин Монголчуудын мал аж ахуй ямар онцлогтой байв вэ? /1 оноо/
 - A. Суурин тариалангийн үйлдвэрлэл давамгайлсан
 - B. Загас агнуур, ан гөрөө түлхүү хөгжсөн
 - C. Арьс шир, торго боловсруулах үйлдвэрлэл давамгайлсан
 - D. Улирлын нүүдэлтэй холбоотой мал аж ахуй хөгжсөн
6. Монгол нутагт нүүдлийн мал аж ахуй хөгжихөд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлох нийт /3 оноо/

Алхам 1: Монгол нутагт нүүдлийн мал аж ахуй хөгжихөд гол нөлөө үзүүлсэн хүчин зүйлийг сонгоно уу. /1 оноо/
 - A. Монгол орны байгаль, цаг уурын орчин
 - B. Монгол нутаг дахь хүн амын тоо, нягтрал
 - C. Газар тариалан эрхлэх боломж муу
 - D. Шашны итгэл үнэмшил

Алхам 2 – Тайлбар бичих: Сонгосон хүчин зүйл Монгол нутагт нүүдлийн мал аж ахуй хөгжихөд хэрхэн нөлөөлснийг 2–3 өгүүлбэрээр тайлбарлана уу. /2 оноо/

.....

.....

.....

7. Дараах овог, аймгуудын аль нь Алунгоо эхийн таван хөвгүүнээс үүссэн гэж Монголын нууц товчоонд дурдагддаг вэ? /1 оноо/

- A. Ойрад, Урианхай, Баргуд B. Тайчууд, Мэргид, Хэрэйд
C. Татар, Найман, Онгуд D. Боржигин, Хатагин, Салжиуд

8. НТ VI зууны дундуур Жужаны Нукуз, Хиян овгууд зүүн зүг нүүж, Эргүнэ гүн хэмээх газар нутаглах болсон шалтгаан аль нь вэ? /1 оноо/

- A. Түрэгийн довтолгооноос дайжиж
B. Дотоодын хямралаасаа болж
C. Шинэ бэлчээр нутаг хайж
D. Эргүнэ гүн мал маллахад тохиромжтой

9. Хүннүгийн хууль цаазын тухай Хятад сурвалжид “Тэдний баримталдаг хуулиар ирт үзүүртийг гаргавал цаазаар аваачна, хулгайн ялтай хүний гэр бүлийг хураана, хөнгөнийг бэрээднэ, хүндийг цаазаар авна” хэмээх мэдээний гол агуулгыг зөв тодорхойлсон нь аль вэ? /2 оноо/

- A. Их Засаг хуулийг Хүннүгийн үед зохиосон
B. Хүннү улсын хуулийг Хятад хуульчид хуулж бичдэг байсан
C. Хүннү улс өөрийн гэсэн хууль цаазтай байсан
D. Хүннүгийн хууль Хятадын Хан улсын хуультай төстэй байсан

10. Сяньби улс хүчирхэг байсныг нотлох сурвалжийн мэдээ аль нь вэ? /1 оноо/

- A. Тэдний зэвсгийн хурц, морины хурдан нь Хүннү нарынхаас нэн хэтийджээ.
B. Малынхаа тоог өсгөж, үүлдэр угсааг нь сайжруулж байв.
C. Умард Хүннүгийн зарим хүн амыг өөртөө нэгтгэжээ.
D. Гар урлал, газар тариалан эрчимтэй хөгжиж байв.

11. “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын далай хааны зарлиг ил болгон иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай” гэх тамганы бичээс аль хааных вэ? /2 оноо/

- A. Чингис хаан B. Өгэдэй хаан
C. Гүюг хаан D. Дээрх бүгд хариулт хамаарна.

12. Их хуралдай нь Монголын төрт ёсны түүхэнд онцгой үүрэг гүйцэтгэсэн байгууллага байсан. Доорх сонголтуудаас хамгийн оновчтой тодорхойлолтыг сонгоно уу (1 оноо)

- A. Төрийн чухал асуудлыг хэлэлцэх, дайн зарлах, улс орны чухал дотоод, гадаад хэргийг хэлэлцэх бичгийн мэргэд, цэцэн билэгт хүмүүсээс бүрэлдсэн эрх бүхий зөвлөл юм.
B. Төрийн чухал асуудлыг хэлэлцэх, хаан сонгох, дайн зарлах, улс орны чухал дотоод, гадаад хэргийг олонхын саналаар шийдвэрийг гаргах эрх бүхий зөвлөл юм.
C. Хааны зөвлөх үүрэгтэй, туршлагатай ноёд, түшмэдээс бүрдсэн зөвлөл бөгөөд төрийн бодлого, хууль цаазын талаар зөвлөгөө өгдөг байв.
D. Төрийн чухал асуудлыг хэлэлцэх, Хааны зөвлөх үүрэгтэй, туршлагатай ноёд, түшмэдээс бүрдсэн зөвлөл бөгөөд төрийн бодлого, хууль цаазын талаар зөвлөгөө өгдөг байв.

Ахлам 2. Яагаад зөв гэж үзсэн шалтгаанаа 2–3 өгүүлбэрээр тайлбарлана уу (2 оноо).

.....
.....
.....

13. 1196 онд Алтан улсаас Монгол улсын хаан Тэмүжинд юуны учир, ямар цол өгсөн бэ? /1 оноо/

- A. Татартай эв найрамдалтай болсон тул Нигүүлсэгч цол
- B. Адуу малаар алба барьсны учир Чингис цол
- C. Алтан улсын албат болсны учир Чингис цол
- D. Улз голд ирсэн Татарыг устгасан учир Жаутхури цол

14. XII–XIV зууны Монголын түүхийн үйл явдлыг удирдагчтай нь зөв харгалзуулна уу. /2 оноо/

Үйл явдал	Удирдагч
1. Их Монгол Улс байгуулагдсан	A. Чингис хаан
2. Хархорум хотыг нийслэл болгосон	B. Өгэдэй хаан
3. Юань гүрэн байгуулсан	C. Хубилай хаан
4. Багдадыг эзэлсэн	D. Хүлэгү хаан

A. 1B, 2C, 3D, 4A B. 1A, 2B, 3C, 4D C. 1A, 2B, 3C, 4D D. 1D, 2A, 3B, 4C

15. Хамаг Монголын анхны хаан Хабулын дараа хэн хаан болсон бэ? /1 оноо/

- A. Хотула B. Есүхэй C. Амбагай D. Хадаан

16. Энэхүү дурсгал хэдий үед холбогдох ямар нэртэй түүхийн дурсгал вэ? /1 оноо/



- A. Юань улсын үеийн цаасан мөнгөний дардас
- B. Хубилай хааны тамганы дардас
- C. Юань гүрний үеийн дөрвөлжин үсэгтэй гэрэгэ
- D. Гүюг хааны тамганы дардас

17. XV–XVII зууны үед Монголын түүх, хууль цааз, уран зохиолын салбарт ямар бүтээлүүд туурвисныг доорх өгүүлбэрийн цэгийн оронд тохирох нэрийг нөхөж бичнэ үү. /3 оноо/

XV-XVII зууны үед Хутагтай Сэцэн хунтайжийн зохиосон (1.) зэрэг хууль цаазын бичиг, Шамба засгийн зохиосон (2.) зэрэг түүхэн зохиол, мөн (3.) зэрэг түүхэн үйл явдлыг уран зохиолын хэлбэрээр бичсэн зохиолууд бичигджээ.

- A. Алтан товч B. Үйсэн дээр бичигдсэн 18 цаазын хураамж
- C. Тогоонтөмөр хааны гэмшил D. Алтан ханы цааз

A. 1A, 2B, 3C B. 1D, 2A, 3C C. 1C, 2A, 3B D. 1B, 2C, 3D

18. Руни бичгийн хамгийн томоохон ямар дурсгал хаанаас олдсон бэ? /2 оноо/

- A. Чин толгойн балгас, Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг
- B. Хар бухын балгасны цогцолбор, Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг
- C. Хэрлэн барс хотын туурь, Дорнод аймаг, Халх гол сумын нутаг
- D. Күль-Тегиний цогцолбор, Архангай аймгийн Хашаат сумын нутаг

19. 1413–1414 онд Мин улсын хаан Юнлэ өөрийн биеэр цэрэг удирдан Хэрлэнд хүрч ирсэн Ойрадын Махамугийн цэргийг бут цохисон үйл явдлын гол шалтгаан юу байв? /1 оноо/
- A. Мин улс Монголчуудыг хагаралдуулах зорилго тавьсан
 - B. Мин улс Монголын хаан ширээний төлөөх тэмцлийг дэмжсэн
 - C. Мин улс Монголын гадаад худалдааг хамгаалахыг зорьсон
 - D. Мин улс Монголын шашны нөлөөг бэхжүүлэхийг хүссэн
20. Монголын түүхэнд XIV зууны сүүлчээс XVII зууныг улс төрийн бутралын үе гэж нэрлэдэг. Улс төрийн бутрал болсон гол шалтгаан юу вэ? /2 оноо/
- A. Олон жил үргэлжилсэн ган, зуд нь улс орны эдийн засгийг доройтуулсан.
 - B. Хаад, ноёдын дарлал хэрээс хэтэрч, дааж давшгүй алба татвар оногдуулах болсноор ард олны бослого тэмцэл байнга гарч улс орныг туйлдуулсан.
 - C. Эдийн засгийн хувьд бэхжин, бие даах чадвартай болсон ноёд, язгууртнууд улс төрийн талаар тусгаарлах гэсэн эрмэлзэл, тэмцлээс үүдэлтэй.
 - D. Мин улсын хагалган бутаргах бодлого, үйл ажиллагааны нөлөөллөөс
21. Монголын түүхийн “Шар тууж”-ийн сурвалж бичгийн “Зургаан түмэн Монголын магтаал”-д “Хулан гөрөөсийг идэж, Хулгар тарвагаар зулам хийж, Хулгайч дээрмийн даруул болсон, Худгийн усыг гаргагч” хэмээх улс төрийн бутралын үеийн зүүн Монголын нэгэн түмнийг магтсан байдаг. Энэ нь аль түмэн вэ? /2 оноо/
- A. Цахар түмэн
 - B. Ордос түмэн
 - C. Урианхай түмэн
 - D. Халх түмэн
22. 1640 онд Халх, Ойрадын ноёд "Их цааз" хэмээх хуулийг батлах болсон гол шалтгаан юу вэ? /1 оноо/
- A. Хошууд улсын эсрэг хүчээ нэгтгэхийн тулд
 - B. Монголд бурхны шашны улааны урсгалыг дэлгэрүүлэх зорилгоор
 - C. Өвөр Монгол Манжид эзлэгдэж харийн түрэмгийлэл ойртсон учир
 - D. Монголын их хааны засаглалыг сэргээх зорилгоор
23. Ойрадын Тогоон тайшийн “... Түүний мэдэл доорх Монгол нь яг буургүй тэмээ, бухгүй үхэр, азаргагүй адуу мэт” хэмээсэн нь Монголын түүхийн аль үед хамаарах вэ? /2 оноо/
- A. XII-XIII зууны Их Монгол улсын үе
 - B. XIV–XVII зууны Монгол
 - C. XIV-XIV зууны Монгол гүрний үе
 - D. XV-XVII зууны Манж Чин улсын үе
24. XIV–XVII зууны Монголын нийгмийн бүтэц дэх ноёд, тайж нарын гол үүрэг юу байсан бэ? /1 оноо/
- A. Бүс нутгийн захиргаа, цэргийн удирдлагыг хариуцах
 - B. Төрийн дээд эрхийг барих
 - C. Худалдаа, арилжаа эрхлэх
 - D. Шашны ёслол гүйцэтгэх

25. Шарын шашин Монголд дэлгэрснээр дараах нөлөөнүүд илэрсэн. Аль нь түүхэн ач холбогдолгүй хэт нэг талыг барьсан үзэлд хамаарах вэ?
- A. Монголчууд оюун санааны хувьд нэгдмэл болсон
 - B. Төвөд, Энэтхэгийн соёлын элементүүд нэвтэрсэн
 - C. Бөө мөргөлийн зарим уламжлалт ёсыг шинэчилсэн
 - D. Шарын шашин бичгийн соёлыг устгаж, мэдлэгийг үгүй хийсэн гэдэг нь туйлширсан дүгнэлт юм
26. 1755-1758 онуудад Хотгойдын Чингүнжав, Хойдын Амарсанаа нар халх ойрадын бослогыг эхлүүлж манжийн эсрэг тэмцсэн тухайн бослого дарагдсан гол шалтгаан аль вэ? /1 оноо/
- A. Нэгдмэл зохион байгуулалт, төвлөрсөн удирдлагагүй байсан.
 - B. Бослогын удирдагчид өөр хоорондоо зөрчилдөж байсан.
 - C. Зарим нөлөө бүхий Ноёд Манжид урвасан.
 - D. Манжийн цэргийн зохион байгуулалт, тулалдах арга барил сайн байсан.
27. Манжийн төрөөс монголын хаад, ноёдод хээл хахууль, амлалт өгч, тэднийг өөртөө татан, Монголын тусгаар тогтнолыг алдагдуулах бодлого явуулсан нь ямар үр дагаварт хүргэсэн бэ? /2 оноо/
- A. Монголын ноёд Манжийн төрийн албан хаагчдад хээл хахууль өгч, хэргэм, зэрэг, албан тушаал ахих явдал түгээмэл болсон.
 - B. Монголын ард түмэн Манжийн төрийн бодлогыг эсэргүүцэн бослого гаргасан.
 - C. Монголын ноёд Манжийн төрийн эсрэг нэгдэж, тусгаар тогтнолоо хамгаалсан.
 - D. Монголын ноёд Манжийн төрийн бодлогыг бүрэн дэмжиж, тусгаар тогтнолоо хадгалсан.
28. 1900 онд Энхтайван хүндийн удирдлага дор Улиастайд гарсан 2000 цэргийн бослогын гол шалтгаан юу байсан бэ? /1 оноо/
- A. Хошуу ноёдын эрх мэдлийг нэмэгдүүлэх хүсэл
 - B. Манжийн засгийн газрын цэргийн албанд дайчлах шийдвэрийг эсэргүүцэх
 - C. Шашны шинэчлэл хийх шаардлага
 - D. Гадаад худалдааг өргөжүүлэх зорилго
29. XIX зууны дунд үеэс XX зууны эхэн хүртэл Монголын ард түмний дунд өрнөсөн нууц, зохион байгуулалттай эсэргүүцлийн нэг хэлбэрийг “дугуйлан” гэж нэрлэдэг. Энэ нэршлийн утга, гарал үүсэл, онцлогийг зөв тодорхойлно уу.
- A. Гишүүдийн нэрийг дугуй хэлбэрээр бичиж, удирдагчийг нууцлах зорилгоор нэрлэсэн
 - B. Тэмцлийн хэлбэр нь дугуй унахтай холбоотой
 - C. Хошууны ноёдын зөвлөлдөх уулзалт
 - D. Хувьсгалт хөдөлгөөний нэр
30. Манжийн засаг захиргаа болон хятад худалдаачдын мөлжлөгийн эсрэг лам нарын удирдлагаар өрнөсөн тэмцлийн үр дүнд гарсан өөрчлөлтүүдээс аль нь хамаарахгүй вэ? /2 оноо/
- A. Лам нарын эдийн засгийн хүч чадал нэмэгдсэн
 - B. Хятад худалдаачдын нөлөө буурсан

- С. Манжийн засаг захиргааны эрх мэдэл нэмэгдсэн
D. Мөнгө хүүлэлт зогссон
31. Манжийн эрхшээлийн үед Монголд мөрдөгдөж байсан хуулиудаас "Монгол хууль" хэмээн нэрлэгддэг нь аль нь вэ? /1 оноо/
A. Дөчин дөрвөн хоёрын их цааз
B. Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйн бичиг
C. Халх журам
D. Монгол цаазын бичиг
32. Монголчуудын дараах тэмцэл, хөдөлгөөнөөс Манжийн ноёрхлын эсрэг гарч байсан тэмцэлд аль нь хамрагдах вэ? /2 оноо/
A. Заргын, өрийн данс шатаах, зэвсэгт тэмцэл, оргон зайлах, дугуйлан байгуулах, сайн эрсийн тэмцэл
B. Өрийн данс шатаах, зэвсэгт тэмцэл, оргон зайлах, дугуйлан байгуулах, сайн эрсийн тэмцэл
C. Заргын, гадаад орон дүрвэх, зэвсэгт тэмцэл, оргон зайлах, дугуйлан байгуулах, сайн эрсийн тэмцэл
D. Заргын, өрийн данс шатаах, зэвсэгт тэмцэл, оргон зайлах, дугуйлан байгуулах, шүүхэд өргөдөл гаргах
33. "Өөртөө засан тогтнох эрх" гэдэг нь тухайн улс аливаа гадаад нөлөөнөөс ангид, дотоод хэрэгтээ өөрөө хяналт тогтоох явдлыг илэрхийлнэ. Энэ ойлголтыг олон улсын улс төрийн ямар нэр томъёогоор илэрхийлдэг вэ? /1 оноо/
A. Статус кво B. Сувернитет эрх C. Дагуул эрх D. Автономит эрх
34. 1911 оны хувьсгалд VIII Богд Жавзандамба хутагт ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? /1 оноо/
A. Их шавийн яамд онцгой эрх олгож хувьсгалыг удирдах газар болгосон
B. Халх, дөрвөдийн ноёдод цалин пүнлүү олгож хувьсгалын хэрэгт татан оролцуулсан
C. Монголын ноёд язгууртнуудын хамт тусгаар тогтнолын тэмцлийг тэргүүлэн удирдсан
D. Манж сайд Сандотой хэлэлцээр хийж тусгаар тогтнолоо зөвшөөрүүлсэн
35. 1913 оны "Бээжингийн тунхаг бичиг"-ийн агуулга аль вэ? /1 оноо/
A. Орос улс Монголд дахь хятадын эзэн эрхийг, Монголын автономит эрхийг ДИУ тус тус зөвшөөрсөн
B. Гадаад Монголыг Орос улсын автономит болохыг ДИУ зөвшөөрсөн
C. Монголын тусгаар тогтнолыг Хятад, Орос улс зөвшөөрсөн
D. Гадаад Монголыг ДИУ-ын муж болохыг Орос улс зөвшөөрсөн
36. 1921 оны 11-р сарын 1-нд Богд хаан ба Ардын Засгийн газар хооронд байгуулсан "Тангаргийн гэрээ"-ний үндсэн зорилго, түүхэн ач холбогдлыг зөв тодорхойлно уу.
A. Ардын засгийн газар ба Богдын харилцааг хуульчлан зохицуулсан
B. Засгийн газрын шийдвэрийг Богд хаан нэг удаа цуцлах, хорих тавих эрхтэй
C. Онцгой нөхцөлд Засгийн газар хаанд айлтгахгүйгээр шийдвэр гаргах эрхтэй
D. Дээрх хариулт бүгд зөв
37. 1922 оны 1-р сарын 25-нд Ардын Засгийн газраас гаргасан шийдвэрийн гол агуулга юу байсан бэ? /2 оноо/
A. Хамжлагыг сумын ардын нэгэн адил тооцох шийдвэр гаргаж, хамжлагын дөнгөнөөс чөлөөлөх анхны алхмыг хийв.

В. Ноёд, тайж нарын хамжлага захирах эрхийн тамгыг хураан авч, феодалын эрх мэдлийг хязгаарлав.

С. Монгол Улсын анхны Үндсэн хуулийг баталж, ардчилсан төрийн тогтолцоог бүрдүүлэв.

Д. Гадаадын худалдаачдад төлөх өрийг хүчингүй болгож, эдийн засгийн тусгаар тогтнолыг хангаж эхлэв.

38. 1924 оны 6-р сарын 2-нд Монгол, Зөвлөлт Орос улсын хувь нийлүүлсэн хөрөнгөөр банк, санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх чухал үйл явдал болсон. Тухайн үеийн банк, санхүүгийн тогтолцоонд ямар чухал үйл явдал болсон бэ? /2 оноо/

А. Үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийг гүйлгээнд гаргасан.

В. Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк (Монголбанк) байгуулагдсан.

С. Монгол Улсын анхны Үндсэн хуулийг баталсан.

Д. Монгол Улс НҮБ-ын гишүүн болсон.

39. Социализмын нийтлэг шинжүүдэд үл хамаарах зүйл дурдсан байна уу? /1 оноо/

А. Нам төвтэй улс төрийн тогтолцоог хуульчлан баталсан.

В. Марксизм-Ленинизм цорын ганц зөв онол хэмээн сурталчилна.

С. Хүмүүсийн бүтээлч сэтгэлгээ, олон ургалч үзлийг бүхий л талаар дэмжиж байв.

Д. Дан ганц улс нийгмийн өмч ноёрхоно.

40. 1924–1990 оны хоорондох БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг хамгийн оновчтой илэрхийлсэн гурван шинжийг сонгоно уу. /3 оноо/

А. Хувийн өмчийг халж, нийгмийн өмчийг ноёрхуулах бодлого явуулсан

В. Гадаад худалдааг чөлөөт зах зээлийн зарчмаар явуулсан

С. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоог хэрэгжүүлсэн

Д. Социалист аж ахуйн нэгдлүүдийг албадан байгуулсан

Е. Ард иргэд үйлдвэрлэл, өмч хөрөнгөө чөлөөтэй хувьчилж авсан

Ү. БНМАУ ЗХУ-тай эдийн засгийн огт хамтын ажиллагаагүй байсан

41. Социализмын үед малыг албадан нийгэмчилсний сөрөг үр дагаварт хамрахгүй зүйл аль нь вэ? /1оноо/

А. Малчид төрийн албыг илүүд үзэх болж, мал аж ахуйг мэргэжлийн хүмүүс эрхлэх болсон
В. Малчид үйлдвэрлэлийн хэрэгслээс салж, хөдөлмөрлөх сонирхол буурсан

С. Малчид малаа нядлах, зарж борлуулах нь ихэссэнээс мал сүргийн тоо буурсан

Д. Айл саахалтаар хамтран мал маллах уламжлалт арга устсан

42. Монгол улсын аль Үндсэн хуулинд анх удаа “МАХН бол улс нийгмийн бүх байгууллагуудыг удирдах гол хүчин” гэж хуульчилсан бэ? (2 оноо)

А. 1924 оны Үндсэн хууль

В. 1940 оны Үндсэн хууль

С. 1960 оны Үндсэн хууль

Д. 1992 оны Үндсэн хууль

43. 1924–1990 оны БНМАУ-ын соёлын хөгжлийн онцлогийг илэрхийлсэн хамгийн зөв хариултыг сонгоно уу. /1 оноо/

Асуулт: 1924–1990 оны БНМАУ-ын соёлын хөгжилд аль нь хамгийн онцлог шинж байв?

А. Ард иргэд шашин шүтэх, уламжлалт зан үйлээ чөлөөтэй эрхэлж байсан

В. Соёлын байгууллагууд ардчилсан зарчмаар бие даан ажилласан

С. Үндэсний уламжлалт соёл нь төрийн бодлогын төвд байж, хязгаарлалгүй дэмжсэн

Д. Соёлын бодлого социалист үзэл сурталд тулгуурласан, төвлөрсөн удирдлагатай байсан

44. БНМАУ-ын тусгаар тогтнолын бэхжилт, гадаад харилцаа өргөжсөнтэй холбоотой баримтыг сонгоно уу. /2 оноо/

Асуулт: Дараах баримтуудаас БНМАУ-ын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд баталгаажуулж, гадаад харилцаагаа өргөжүүлсэн гол нотолгоонд аль нь хамаарах вэ?

- A. 1915 оны Гурван улсын гэрээ
- B. 1928 оны БНМАУ-ын анхны Засгийн газрын тогтоол
- C. 1940 оны шинэ Үндсэн хууль батлагдсан
- D. 1945 оны бүх ард түмний санал хураалт

45. 1989, 12.10-нд Залуучуудын соёлын төвийн үүдэнд зохион байгуулсан цуглаан дээр С.Цогтсайхны дуулсан дуу ямар нэртэй вэ? /1 оноо/

- A. Хонхны дуу
- B. Эх орны өглөө
- C. Сэрсэн тал
- D. Ардчилалын дуу

46. 1990 оны Ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол Улсад ямар өөрчлөлт бодитоор хэрэгжсэн бэ? /2 оноо/

- A. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг улам бүр бэхжсэн
- B. Олон намын тогтолцоонд шилжиж, шинэ Үндсэн хууль батлагдсан
- C. Нэг намын засаглалыг хадгалан үлдсэн
- D. Хуучин Үндсэн хуулийг шинэчлэх хэлэлцээр цуцлагдсан

47. Өмч хувьчлалын хууль 1991 оны 5 сарын 31-ий өдөр батлагдаж, үүнээс өмнө төрсөн Монгол улсын иргэдэд олгосон 7000 төгрөгийн үнэ бүхий ягаан тасалбар өмч хувьчлалын аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. Газар хувьчлал
- B. Их хувьчлал
- C. Орон сууцны хувьчлал
- D. Бага хувьчлал

48. Доорх баримтаас Монголын төрд ямар шийдвэр гарсныг тодорхойлно уу.

“...МАХН Төв Хорооны Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох, шинэ Үндсэн хууль боловсруулах талаар санал оруулсан...” /1 оноо/

- A. МАХН-ын зүгээс залуучуудын шаардлагыг хүлээн зөвшөөрсөн
- B. Улс төрийн шинэчлэл эхлэх нөхцөлийг бүрдүүлсэн
- C. Ардчилсан намыг бүртгэх тухай шийдвэр
- D. Цэргийн эргэлт зохион байгуулахаар болсон

49. 1980-аад оны дунд үе гэхэд БНМАУ-ын социалист байгуулалт мухардмал байдалд орсон бөгөөд үүнд нөлөөлсөн шалтгаан, хүчин зүйлсийг нийгмийн амьдралын хүрээ тус бүртэй нь зөв тохируулна уу. /2 оноо/

Нийгмийн хүрээ	Холбогдох хүчин зүйл
A. Улс төрийн хүрээ	1. Нэг намын дарангуйлал, захиран тушаах дэглэм
B. Оюун санааны хүрээ	2. Марксизм-ленинизмийг цорын ганц зөв онол хэмээн тулгаж, сэтгэлгээний эрх чөлөө, олон ургалч үзлийг хаан боогдуулж байв.

С. Соёлын хүрээ	3. Үндэсний өв уламжлалаа өнгөрсөн нийгмийн үлдэгдэл хэмээн үзэж байв.
Д. Эдийн засгийн хүрээ	4. Зөвхөн улсын буюу нийгмийн өмчийг хүлээн зөвшөөрч, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо ноёлж байв.

А. 1А, 2В, 3С, 4D В. 1А, 2С, 3D, 4В С. 1А, 2D, 3В, 4С D. 1А, 2С, 3В, 4D

50. Монгол Улс терроризмтой тэмцэх олон улсын ажиллагаанд цэргийн бие бүрэлдэхүүнээ оролцуулсан. Энэ жишээнээс Монгол Улсын гадаад бодлогын чиг хандлагыг аль нь хамгийн оновчтой илэрхийлэх вэ? /2 оноо/

- А. Монгол Улс шаардлагатай тохиолдолд үй олноор хөнөөх зэвсгийг нутаг дэвсгэртээ байршуулах боломжтой болдог
- В. Монгол Улс олон улсын цэргийн эвсэлд нэгдэн орж, гишүүнчлэлээ бэхжүүлдэг
- С. Монгол Улс энхийг эрхэмлэж, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг
- Д. Монгол Улс үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн тохиолдолд л цэргийн ажиллагаанд оролцдог.

_____оОо_____

УЛСЫН ШАЛГАЛТ - 2025

ТҮҮХ
XII АНГИ
В хувилбар

Аймаг/дүүрэг:

Сум:.....

Сургууль:

Анги:..... бүлэг:.....

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Амжилт хүсье.

ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН 12 ДУГААР АНГИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ

В ХУВИЛБАР

80 МИНУТ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Аль нь хуучин чулуун зэвсгийн дунд үе вэ? /1 оноо/

- A. 800 000-100 000 жилийн үед B. 100 000-40 000 жилийн үед
C. 40 000-15 000 жилийн үед D. 15 000-8000 жилийн үед

2. Түрэгийн үеийн түүхийг судлахад голчлон ямар эх сурвалж ашиглагддаг вэ? /2 оноо/

- A. Монголын нууц товчоо B. Хятад, Солонгосын түүхэн сурвалжууд
C. Оросын түүхэн сурвалжууд D. Түрэгийн бичээсүүд

3. Дараах шинжүүдээс хүрэл ба төмөр зэвсгийн үеийн аймгийн нэгдэлд хамаарахгүй шинжийг сонгоно уу. /1 оноо/

- A. Аймгууд төрийн тогтолцоотой байсан B. Тогтсон газар нутагтай байсан
C. Нэгэн ижил хэл аялгуугаар ярьдаг байсан.
D.. Аймгууд өөр өөрийн нэртэй байсан.

4. Дараах баримтыг уншаад тохирох дүгнэлтийг хийнэ үү? /2 оноо/

“Жужаны хаан буддын шашны судар, их бага ухааныг тайлж эзэмшсэн лам Дармаприяг төрийн багшаар өргөмжлөн 3000 өрх соёрхон олгожээ” гэх мэдээнээс хамгийн оновчтой дүгнэлтийг сонгоно уу. /2 оноо/

- A. Жужан улс буддын шашныг төрийн түвшинд хүлээн зөвшөөрсөн
B. Буддын шашин төрийн албанд нөлөөлж эхэлсэн
C. Лам нарын нийгмийн байр суурь өсч эхэлсэн
D. Дээрх бүх хариулт үнэн

5. Монголчууд мал аж ахуйнхаа аль элемент дээр тулгуурлан нүүдлийн амьдралыг зохион байгуулдаг байв вэ? /1 оноо/

- A. Улирал, цаг уурын нөхцөл B. Төрийн төвлөрсөн захиргаа
C. Газар тариалангийн хөрсний бүтцээс D. Худалдааны замын байршлаас

6. Алхам 1. Дараах хүчин зүйлүүдээс Монгол нутагт нүүдлийн мал аж ахуй хөгжихөд гол нөлөө үзүүлсэн хүчин зүйлийг сонгоно уу. /1 оноо/

- A. Хүн амын тоо, нягтрал B. Байгаль, цаг уурын нөхцөл
C. Газар тариалан эрхлэхэд таагүй байдал
D. Шашны үзэл суртал

Алхам 2. Сонгосон хүчин зүйл Монгол нутагт нүүдлийн мал аж ахуй хөгжихөд хэрхэн нөлөөлснийг 2–3 өгүүлбэрээр тайлбарлана уу. /2 оноо/

.....
.....
.....

7. “Монголын нууц товчоо”-ны 199-р зүйлд дурдагдсан “Дуун бариулах” гэдэг нь юу гэсэн утгатай вэ? /1 оноо/

- A. Шүлэг зохиох
B. Үг хэлэлцэн, ярилцах
C. Найранд дуулж, хуурдах
D. Тогтоон цээжилж явах зарлиг

8. “Монголын нууц товчоо”-ны хамгийн эртний олдсон эх ямар хэлбэртэй байсан бэ? /1 оноо/

- A. Монгол бичгээр
B. Хятад үсгээр, Монгол хэлээр
C. Латин үсгээр
D. Төвд үсгээр

9. Хан улсын хуанди, Хүннүгийн шаньюйд “Урт цагаан хэрмээс хойшхи нум сум агсагчдын улс нь шаньюйн зарлигийг дагаж, Цагаан хэрэмнээс урагш түшмэдийн бүс, малгай өмсөгчид суудаг орон нь харин надад захирагдана” хэмээх сурвалжийн мэдээний гол агуулгыг зөв тодорхойлсон нь аль вэ? /2 оноо/

- A. Хан улс Хүннү улсыг хүлээн зөвшөөрч, Цагаан хэрмээр хилээ тогтоосон
B. Хан улс, Хүннү улсад бүрмөсөн бууж өгсөн
C. Хүннү улс, Хан улсын найрсаг харилцаа тасарч, дайны байдалд шилжсэн
D. Хүннү нар хүчирхэг нум сумт цэрэгтэй байсан

10. Эртний Жужан улс тухайн үеийн нүүдэлчдийн онцлогийг илтгэсэн ямар цэргийн бүтэц, зохион байгуулалттай байв? /1 оноо/

- A. Хишигтэн болон тээврийн зориулалттай морин цэрэг ашигладаг байв
B. Хүнд хуягт болон хөнгөн зэвсэгт морин цэрэг давамгайлж байв
C. Морин ба явган цэргийн хосолсон бүтэцтэй байв
D. Морин тэрэг болон нум сумт явган цэрэг голлодог байв

11. Мөнх хаан 1259 онд нас барсны дараа Монголын эзэнт гүрэн задран бутарч, нэгдмэл байдал нь алдагдсан. Дараах нөхцөл байдлуудаас аль нь энэ задралын гол шалтгаанд хамаарахгүй вэ? (2 оноо)

- A. Хубилай хаан болон Аригбөхийн хооронд хаан ширээний төлөө иргэний дайн эхэлсэн.
B. Мөнх хааны дараагийн хаан тодорхойгүй байсан нь улс төрийн тогтворгүй байдлыг үүсгэсэн.
C. Монголын эзэнт гүрэн дотоодын хуваагдал, иргэний дайнд автсан.
D. Гадаадын довтолгоонууд Монголын эзэнт гүрнийг хүчээр хуваасан.

12. Сэцдийн зөвлөл нь Монголын төрийн шийдвэр гаргах чухал байгууллагын нэг байв. Доорх тодорхойлолтуудаас аль нь түүний үүргийг хамгийн оновчтой илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. Хааны туслах зөвлөхүүдийн жижиг бүлэг бөгөөд цэргийн бодлогын зөвлөгөө өгдөг
B. Туршлагатай ноёдоос бүрдсэн, төрийн бодлогыг хэлэлцэж шийдвэр гаргадаг эрх бүхий зөвлөл
C. Чухал асуудлаар хэлэлцдэг боловч эцсийн шийдвэр гаргах эрхгүй
D. Шашны болон ёслолын асуудлыг зохицуулдаг тусгай бүлэг

Ахлам 2. Яагаад зөв гэж үзсэн шалтгаанаа 2–3 өгүүлбэрээр тайлбарлана уу (2 оноо).

.....
.....
.....

13. “Жаутхури” гэдэг нь аль улсын цол бэ? /1 оноо/
А. Алтан улсаас Тэмүжинд олгосон цол хэргэм
В. Тухайн үеийн Хятад улсын төрийн цол
С. Татарын тэргүүлэгч жанжины цол
D. Монголын Тэргүүлэгч цэргийн жанжин цол
14. Доорх түүхэн үйл явдлуудаас аль нь хамгийн сүүлд болсон бэ? /2 оноо/
А. Их Монгол улс байгуулагдсан В. “Их Засаг” хуулийг зарласан
С. Хархорумыг нийслэл болгосон D. Юань гүрнийг байгуулсан
15. Өүлэн үжин аль аймгийн хүн бэ? /1 оноо/
А. Хонгирад В. Татар С. Олхунуд D. Мэргэд
16. Энэхүү дурсгал хэдий үед холбогдох ямар нэртэй түүхийн дурсгал вэ? /1 оноо/



- А. Юань улсын үеийн цаасан мөнгөний дардас
В. Хубилай хааны тамганы дардас
С. Юань гүрний үеийн хүрэл гэрэгэ
D. Гүюг хааны тамганы дардас

17. XV–XVII зууны үед Монголын түүх, хууль цааз, уран зохиолын салбарт ямар бүтээлүүд туурвисныг доорх өгүүлбэрийн цэгийн оронд тохирох нэрийг нөхөж бичнэ үү. /3 оноо/

XV-XVII зууны үед Хутагтай Сэцэн хунтайжийн зохиосон (1.) зэрэг хууль цаазын бичиг, Шамба засгийн зохиосон (2.) зэрэг түүхэн зохиол, мөн (3.) зэрэг түүхэн үйл явдлыг уран зохиолын хэлбэрээр бичсэн зохиолууд бичигджээ.

- А. Алтан товч В. Үйсэн дээр бичигдсэн 18 цаазын хураамж
С. Тогоонтөмөр хааны гэмшил D. Алтан ханы цааз
- А. 1A, 2B, 3C В. 1C, 2A, 3B С. 1D, 2A, 3C D. 1B, 2C, 3D
18. Эртний нэгэн улс “Их бичиг”, “Бага бичиг” гэх түүхийн баримтыг хөтөлж байжээ. Энэ нь тухайн улсын дотоод ба гадаад бодлого, шастирыг тэмдэглэн үлдээдэг байсныг гэрчилнэ. Аль улс вэ? /2 оноо/
А. Хүннү В. Кидан С. Уйгур D. Түрэг
19. Монголын улс төрийн бутрал, дажин хямрал үүсэхэд ямар хүчин зүйл голлон нөлөөлсөн бэ? /1 оноо/
А. Их хааны эрх мэдэл буурч, төрийн эрх сайд тайш нарын гарт төвлөрсөн
В. Гадаадын түрэмгийлэл нэмэгдсэн
С. Шашны нөлөө нэмэгдсэн D. Эдийн засгийн хямрал
20. XIV зууны сүүлчээс XVII зууныг хамарсан Монголын улс төрийн бутралын үед эдийн засгийн байдал хэрхэн өөрчлөгдөж, ямар хүчин зүйлс нөлөөлсөн бэ? /2 оноо/
А. Төвлөрсөн захиргааны тогтолцоо бүрэн тогтож, эдийн засаг хүчтэй, хөгжилтэй болсон.
В. Мин улсын эдийн засгийн бодлого Монголд бүрэн нэвтэрч, эдийн засаг Мин улсын хяналтад орсон.

- С. Гадаад худалдаа идэвхжиж, Торгоны замын ачаар эдийн засаг тогтвортой байдалд хүрсэн.
- Д. Хаад, ноёдын хоорондын эрх мэдлийн тэмцэл, төвлөрсөн захиргааны сулрал, байгалийн гамшиг зэрэг олон хүчин зүйлсийн улмаас эдийн засаг доройтсон, хямралтай болсон.
21. Монголын түүхийн “Шар тууж”-ийн сурвалж бичгийн “Зургаан түмэн Монголын магтаал”-д “Хангай ханыг арлан сууж, Харь дайсанд чинь халх болсон, Халуун аминд чинь түшээ болсон, Харахын харуул, ирэхийн үзүүр болсон.....” хэмээх улс төрийн бутралын үеийн зүүн Монголын нэгэн түмнийг магтсан байдаг. Энэ нь аль түмэн вэ? /2 оноо/
- А. Цахар түмэн В. Халх түмэн С. Урианхай түмэн Д. Ордос түмэн
22. Батмөнх Даян хааны 1470–1517 оны хооронд төр барьсан хугацаанд Монгол оронд дотоодын зөрчил, дайн дажин намжиж, төвлөрсөн засаглал тогтсон энэ үеийг түүхэнд юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
- А. "Их Монгол Улсын мандалт" В. "Монголын нэгдлийн үе"
С. "Даян хааны энх тайвны үе" Д. "Хаадын хагаралтын үе"
23. Түүх сударт тэмдэглэгдсэн “Дөчин түмэн Монголын эзэн баатар, Чингис хааны зарлиг” хэмээн өөрийгөө хэн хэлсэн бэ? /2 оноо/
- А. Батмөнх даян хаан В. Түмдийн Алтан хан
С. Манжийн хаан Нурхач Д. Лигдэн Хутугт хаан
24. XIV–XVII зууны Монголын нийгмийн бүтэц дэх энгийн ард иргэдийн гол үүрэг юу байсан бэ? /1 оноо/
- А. Мал аж ахуй эрхлэх, алба татвар төлөх В. Шашны ёслол гүйцэтгэх
С. Төрийн дээд эрхийг барих Д. Гадаад худалдаа эрхлэх
25. Монголд бурхны шашин дэлгэрсний эерэг нөлөө аль вэ? /2 оноо/
- А. Монголчуудыг энэрэнгүй, номхон хүлцэнгүй болгосон
В. Алтан ургийн язгууртнууд оны цол хэрэглэх болсон
С. Монголчуудын оюун санааны нэгдмэл байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх болсон
Д. Хүн амын өсөлтөнд эерэгээр нөлөөлсөн
26. 1756 онд Халх Монголд Хотгойдын шадар ван Чингүнжавын удирдлага дор эхэлсэн Манжийн эсрэг бослого ямар хэлбэрээр эхэлсэн бэ? /1 оноо/
- А. Манжийн цэргийн албыг орхиж, зэвсэгт бослого өрнүүлэх
В. Хятадын мөнгө хүүлэгч пүүсүүдийг хөөх
С. Манжийн цэрэгтэй шууд тулалдах
Д. Дугуйлангийн хөдөлгөөн байгуулан тэмцэх
27. Манжийн эрхшээлд байх хугацаанд Монголын уламжлалт соёл, ёс заншилд ямар өөрчлөлт гарсан бэ? /2 оноо/
- А. Монголчуудын хувцаслалтанд Манжийн төрийн зэрэг дэвийг илэрхийлсэн ялгаа гарч, малгай, дээл, бүс зэрэг нь зэрэг дэвээр ялгагдах болсон.
В. Монголчууд уламжлалт хувцас, ёс заншлаа бүрэн хадгалж, гадаад соёлын нөлөөнд автаагүй.
С. Монголчууд Манжийн соёлыг бүрэн хүлээн авч, өөрийн соёл, ёс заншлаа орхисон.
Д. Монголчуудын соёл, ёс заншилд ямар ч өөрчлөлт гараагүй.

28. 1905 оны намар Жирэмийн чуулганы өмнөд Горлос хошуунд Тогтох тайжийн удирдлагаар гарсан зэвсэгт бослогын гол шалтгаан юу байсан бэ? /1 оноо/
- A. Шашны шинэчлэл хийх шаардлага
 - B. Гадаад худалдааг өргөжүүлэх зорилго
 - C. Манжийн эрхшээл, хятад худалдаачдын мөлжлөгийн эсрэг эсэргүүцэл
 - D. Хошуу ноёдын эрх мэдлийг нэмэгдүүлэх хүсэл
29. Хошууны ноёд, хятад худалдаачдын хууль бус үйлдлийг эсэргүүцэн ард олныг удирдан зарга мэдүүлсэн Алдаржавын Аюуш (Ард Аюуш) ямар үйл ажиллагаагаараа түүхэнд алдаршсан бэ? /2 оноо/
- A. Хошуу ноёныг дэмжих
 - B. Зарга мэдүүлж, зэвсэгт бослого зохион байгуулах
 - C. Шашны номлол хийх
 - D. Гадаад худалдааг хөгжүүлэх
30. Өвөр Монголын нүүдэлчид хятадын тариачдыг суурьшуулах бодлогыг эсэргүүцэхдээ ямар арга хэлбэрүүдийг ашигласан бэ? /2 оноо/
- A. Зарга мэдүүлэг, зэвсэгт эсэргүүцэл, соёлын эсэргүүцэл
 - B. Хятадын засгийн газартай хэлэлцээр хийх
 - C. Шашны номлол хийх
 - D. Гадаад орнуудын тусламж хүсэх
31. Манж Чин улсын "Шинэ засгийн бодлого"-ын эсрэг Монголчуудын хариу үйлдэл юу байсан бэ? / 1 оноо/
- A. Бодлогыг бүрэн дэмжсэн
 - B. Гадаадын орнуудтай холбоо тогтоосон
 - C. Хятадын соёлыг нэвтрүүлсэн
 - D. Эсэргүүцэл үзүүлж, тусгаар тогтнолын төлөө тэмцсэн
32. Манж Чин гүрний Монголыг XVII–XIX зууны дунд хүртэл хэрэгжүүлсэн гол бодлогын чиглэлд ямар нэгэн байдлаар хамаарахгүй сонголтыг сонгоно уу. / 2 оноо/
- A. Монголыг хошуу, чуулганы зохион байгуулалтанд оруулж, төвөөс удирдах бүтэцтэй болгосон.
 - B. Монголд хятад худалдаачдыг нэвтрүүлэх, газар хагалбаруулахыг дэмжсэн.
 - C. Монголчуудын уламжлалт аж төрөх байдлыг хадгалж, хэрэгтэй цагт ашиглах зорилго бүхий байв.
 - D. Монгол нутагт уул уурхай нээх, газар хагалахыг хориглож, хятад худалдаачдыг зөвхөн тодорхой зөвшөөрөл, хугацаагаар орохыг зөвшөөрч байв.
33. “Автономит эрх” гэж ямар утгатай улс төрийн хэллэг вэ? /1 оноо/
- A. Бусад улс оронд ноёрхлоо тогтоосон
 - B. Бүрэн эрхт тусгаар улс
 - C. Өөртөө засан тогтнох эрх
 - D. Төвийг сахисан
34. С. Данзангийн байгуулсан улс төрийн бүлгэм аль нь вэ? /1 оноо/
- A. Консулын дэнжийн бүлгэм
 - B. Ноёдын бүлгэм
 - C. Язгууртан, түшмэдийн бүлэг
 - D. Зүүн хүрээний бүлгэм
35. 1919 онд хятад элчин Чен И Гадаад Монголын автономийг устгах гэрээг санаачлан боловсруулжээ. Тэрхүү баримт бичиг аль вэ? /1 оноо/
- A. Бээжингийн тунхаг бичиг

- В. Хятад, Орос, Монгол гурван улсын гэрээ
С. Гадаад Монголын хойчийг сайжруулах 64 зүйл бүхий гэрээ
D. Найрамдлын гэрээ бичиг
36. 1921 оны 11 дүгээр сарын 1-нд Богд хаан ба Ардын Засгийн газрын хооронд байгуулсан “Тангарагийн гэрээ”-ний гол агуулга юу вэ? /2 оноо/
A. Монгол Ардын Намын зорилго, бодлогыг тусгасан баримт бичиг
B. Богд хаан ба Засгийн газрын эрх үүргийг тусгасан баримт бичиг
C. Нууц бүлгэмийн гишүүд нууцыг чандлан хадгалах тухай баримт бичиг
D. Орос улсаас нууцаар тусламж гуйх хэрэгт зүтгэгчдийг баталгаажуулсан баримт бичиг
37. 1922 оны 1-р сарын 25-нд Ардын Засгийн газраас гаргасан Хамжлагат ёсыг халснаар хамжлага ардууд ямар эрх эдлэх болсон бэ? /2 оноо/
A. Феодалын захиргаанд үлдэх
B. Гадаад харилцаанд оролцох
C. Шашны үйл ажиллагаанд оролцох
D. Эд хөрөнгө, мал сүрэгтэй болох, татвар төлөх, цэргийн алба хаах
38. 1921 оны 11-р сарын 2-нд анхны бага сургуулийг байгуулсан. Энэ үйл явдлын ач холбогдолд хамаарахгүй зүйл аль нь вэ? /2 оноо/
A. Шинэ үеийн боловсролын тогтолцоог эхлүүлсэн
B. Эрэгтэй эмэгтэй ялгалгүй суралцах боломжоор хангаж эхэлсэн
C. Олон улсад анх удаа ийм сургалт явуулсан
D. Багш бэлтгэх анхан шатны тогтолцоог бий болгосон
39. Социалзмын үеийн нийгмийн амьдралын үзэл суртлын хүрээнд хамаарах өгөгдлийг дурдахдаа алдаа гаргасан бол олно уу? /1 оноо/
A. Марксизм-Ленинизм хэмээх цорын ганц онолд захирагдсан.
B. Мэдээлэл нээлттэй бус хариуцлагын механизм тааруу
C. Шүтэх, эс шүтэх эрх чөлөөг боомилсон.
D. Олон ургалч үзлийг хөхүүлэн дэмжсэн.
40. Монголын урлаг, уран сайхны хөгжилтэй холбоотой гурван зөв хариултыг сонгоно уу. /3 оноо/
A. “Мандухай сэцэн хатан” кино дэлгэцнээ гарсан
B. Улсын драмын театр, кино үйлдвэр байгуулагдсан
C. Бүжгийн урлаг, зураачдын уран бүтээл олон улсын үзэсгэлэнд оролцож эхэлсэн
D. “Интеркосмос” сансрын хөтөлбөрт оролцсон
41. Доорх үзэгдлүүдээс аль нь 1940–1950 оны БНМАУ-д зөвлөлтийн загварын нөлөө гүнзгийрсэн байдалтай аль нь холбогдохгүй вэ? /1 оноо/
A. Нам төрийн нэгдэл бий болж, намын дээд байгууллагууд бүх бодлогыг тодорхойлж байв
B. Ардын Их Хурал олон намын төлөөллийг хүлээн зөвшөөрсөн
C. ЗХУ-ын туршлагыг дуурайж төлөвлөгөөт эдийн засаг, төвлөрсөн удирдлага нэвтэрсэн
D. Үзэл суртлыг нийгмийн бүхий л салбарт нэвтрүүлж, ЗХУ-ын социалист үнэт зүйлийг сурталчилсан
42. Малыг албадан нийгэмчилсний дараах сөрөг үр дагавруудын дунд буруу буюу хамаарахгүй зүйлийг олно уу. / 2 оноо/

- A. Малчдыг үйлдвэрлэлийн хэрэгслээс салгаснаар тэдний мал өсгөх, аж ахуй эрхлэх сонирхол буурсан
- B. Нэгдэлд орохоос зайлсхийж, малчид малаа хядах, зарж борлуулах үйлдэл хийсэн
- C. Гэр бүл, саахалт айлуудын уламжлалт хамтын маллагаа таслагдсан
- D. Малчид улсын өмчийг эрхэмлэж, төлөвлөгөөт хөдөлмөрт идэвхтэй оролцох болсон

43. БНМАУ-ын 1940-1980 оны соёлын хөгжлийн тухай доорх мэдэгдлүүдээс аль нь тухайн үеийн бодит нөхцөл байдалд хамааралгүй вэ? /1 оноо/

- A. Соёлын бүтээлүүдэд социалист үзэл санаа болон ардын хувьсгалын түүх зонхилсон
- B. Уран бүтээлчид улс төрийн удирдлагын нөлөөгүйгээр бүтээл туурвиж байсан
- C. Хөдөлмөрийн хүмүүсийн амьдралыг соёл урлагийн бүтээлүүдэд ихээр өгүүлдэг байсан
- D. Социалист реализм нь тухайн үеийн уран сайхны гол урсгал байсан

44. 1945 оны 10-р сарын 20-нд БНМАУ-д бүх ард түмний санал хураалт явагдсан нь ямар зорилготой вэ? /2 оноо/

- A. Японы эзлэн түрэмгийллийг дуусгах, Дэлхийн II дайнд оролцох шийдвэрийг баталгаажуулахын тулд
- B. Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн заалтуудыг батлах эсэхийг ард түмнээр шийдвэрлэхийн тулд
- C. Дорно дахины улс төрийн нөхцөл байдлын улмаас тусгаар тогтнолоо олон улсад баталгаажуулах зорилгоор
- D. 1945 оны 8-р сард Японыг ялагдсаны дараа Зөвлөлт Холбоот Улс БНМАУ-ын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд

45. 1980 -аад оноос дэлхий социалист систем мухардалд орсныг хүлээн зөвшөөрч улмаар эх орондоо ил тод байдал, өөрчлөн байгуулалтыг зарласан удирдагч хэн бэ? /1 оноо/

- A. М.С.Горбачев B. Л.И.Брежнев C. Ж.Батмөнх D. Ю.Цэдэнбал

46. 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн дараах заалтыг уншаад, утга агуулгатай нь хамгийн ойр хариултыг сонгоорой. /2 оноо/

“Монголын ард түмэн бид улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрлөхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.”

- A. Хүний хувийн өмчийг хүндэтгэнэ B. Дэлхийн олон улстай харилцана
- C. Хүний эрх, эрх чөлөөг хангана D. Нийгмийн журам, хууль дүрмийг дагана

47. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо огцрох шийдвэрийг хэзээ гаргасан бэ? /1 оноо/

- A. 1992.01.13 B. 2008.07.01 C. 1989.12.10 D. 1990.03.09

48. 1997 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ургийн овгийг сэргээн хэрэглүүлэх болсны зорилго юу вэ? /1 оноо/

- A. Монгол улсад жендерийн эрх тэгш байдлыг хангах
- B. Монгол улсын удмын сангийн аюулгүй байлыг хангах
- C. Монгол улсын иргэдийн аюулгүй байдлыг хангах
- D. Монгол улсын дотоод аюулгүй байдлын хангах

49. 1990 оны ардчилсан хувьсгал ялснаар монголчуудын амьдрал дараах 4 хүрээнд хэрхэн өөрчлөгдсөнийг тохируулна уу. /2 оноо/

Хүрээ	Хувьсгалын үр дүн
A. Улс төрийн хүрээ	1. Уламжлалт аж байдал, өв уламжлалаа дээдлэх
B. Оюун санааны хүрээ	2. Өрсөлдөөнт эдийн засаг
C. Соёлын хүрээ	3. Олон намын тогтолцоо
D. Эдийн засгийн хүрээ	4. Үг хэлэх, өөрийн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх

A. 1A 2B 3C 4D B. 1C 2D 3A 4B C. 1D 2B 3C 4A D. 1D 2A 3C 4B

50. 1991 оны 5 сарын 31-нд батлагдсан Өмч хувьчлалын хуулиар Монгол Улсын иргэдэд олгосон 3000 төгрөгийн үнэ бүхий ягаан тасалбар ямар төрлийн хувьчлалын хэлбэр вэ? /2 оноо/

- A. Бага хувьчлал
- B. Их хувьчлал
- C. Орон сууцны хувьчлал
- D. Газар хувьчлал

_____оОо_____